



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/15

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "е", 30 дугаар зүйлийн 30.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хэнтий аймгийн Батширээт, Өмнөдэлгэр сумын нутагт Хуш модны самрын хууль бусаар түүж байгаа үйл ажиллагаанд газар дээр нь дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	А.Гантөмөр	-Татварын хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Дархантөр	-ХАААЖБХорооны дарга
	Б.Сүнгээ	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Б.Эрдэнэбаатар	-Өмнөдэлгэр сумын Засаг дарга

Хоёр. Ажлын хэсгийн үйл ажиллагааны зардалд 445.500 /дөрвөн зуун дөчин таван мянга таван зуун/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

Гурав. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

Дөрөв. Хуш модны самрын хууль бус ашиглалт явагдаж буй газруудад бодит дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээний саналыг нэгтгэн 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /А.Гантөмөр/-д даалгасугай.

2//.

Тав. Хөрөнгө зарцуулахад шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

07
Аймгийн Засаг даргын 2017 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Тоо ширхэг /литр/	Бүгд үнэ /төгрөг/
1	Шатахуун /АИ-92/	1650	270	445.500
	Нийт дүн			445.500